



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн 14.2.3 дахь заалт, 14.3 дахь хэсэг, Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын дүгнэлт, зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд өгсөн Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, нягтлан бодох бүртгэлийн ажлыг сайжруулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын төсвийн багцын нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын дарга (төсвийн шууд захирагч) нарт дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

1.1.Санхүүгийн сахилга батыг сайжруулах, алдаа, дутагдал гаргахгүй байхад анхаарч, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоол, “Монгол Улсын 2022 оны төвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг тус тус ханган ажиллах, нягтлан бодох бүртгэлийн хувьд аудитын шалгалтаар “хязгаарлалттай” дүгнэлт үүсгэсэн, цаашид үүсгэж болзошгүй асуудлыг нэг бүрчлэн шийдвэрлэх,

1.2.Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү,хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэх,

2.Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах, дотоод аудитын нэгжийн болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, шилэн дансны мэдээлэлд тогтмол хяналт тавих талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталж, хэрэгжилтэд хяналт тавихыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (М.Энхболд)-т үүрэг болгосугай.

3.Хоёрдугаар хавсралтад дурдсан “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байгууллагын удирдлагад сануулах арга хэмжээ авах, “сөрөг”, “дүгнэлт өгөхөөс татгалзсан” зэрэг үнэлгээ авсан байгууллагуудын гэрээний үүргийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтэд өгөх үнэлгээний саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон компаниудын ТУЗ-д хүргүүлж, зохих журмын дагуу хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлүүлэх, мөн тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Батболд)-д даалгасугай.

САЙД  Л.ХАЛТАР




080000397

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны ... дугаар сарын 18-ны өдрийн Аргаар тушаалын хавсралт №1

**АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Газар, хэлтэс	Сайдын тушаалаар өгсөн үүрэг	Хэрэгжүүлэх албан тушаалтан		Хийгдэх ажлууд	Биелэлт ирүүлэх хугацаа	Хяналт тавих албан тушаалтан
			ЗТХЯ	Харьяа газар			
1	СХОХ	Сайдын төсвийн багцын байгууллагууд аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллах, биелэлтийг гарган ирүүлэх	Г.Алтангэрэл	Төсөвт болон ТӨҮГ-ын удирдлага	Харьяа байгууллагууд акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх сар, улирлын төлөвлөгөө гарган ажиллах, биелэлтийг сар бүр гаргах, эцсийн байдлаар яаманд ирүүлэх	улирал тутам, эцсийн хугацаа 2022.08.25	Ч.Ренчиндамба
2	ХШУДАГ	Харьяа байгууллагуудын дотоод аудитын нэгжийн болон нягтлан бодох бүртгэлийн ажлын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн санхүүгийн аудитын шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах	У.Эрдэнэчимэг	Төсөвт болон ТӨҮГ-ын удирдлага	Эрсдэлтэй байгууллагуудыг шалгах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2022.12.31	М.Энхболд
3	ХШУДАГ	Харьяа байгууллагуудын шилэн дансны сайтад тавих мэдээллийн иж бүрдэл, үнэн зөв болон хугацаа хоцролтын байдалд шалгалт хийх, хуульд заасан арга хэмжээг авах	У.Эрдэнэчимэг	Төсөвт болон ТӨҮГ-ын удирдлага	Шилэн дансны хөтлөлт, иж бүрдлийн байдалд хяналт тавих,	2022.09.25	М.Энхболд
4	СХОХ	Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, үүрэг даалгавар өгөх	Г.Алтангэрэл У.Эрдэнэчимэг	Төсөвт болон ТӨҮГ-ын удирдлага	Ажлын төлөвлөгөөний биелэлтийг гарган удирдлагад танилцуулах, харьяа байгууллагуудын санхүүгийн ажилтнуудад үүрэг даалгавар өгөх	2022.12.31	М.Энхболд

6	СХОХ	Сөрөг, дүгнэлт өгөхөөс татгалзсан үнэлгээ авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтад хариуцлага тооцох талаар ҮАГ-аас ирүүлсэн албан шаардлагын дагуу ТӨБЗГ, компанийн ТУЗ-д албан бичиг хүргүүлэх	Г.Алтангэрэл	ИНЕГ-ын Сэргээн засах амралт, Завхан АЗЗА компани	Албан шаардлагыг ҮАГ-аас авах холбогдох байгууллагуудад хүргүүлэх	2022.08.25	С.Батболд
7	Хуулийн хэлтэс	Олон жилийн насжилттай авлагуудыг хуулийн байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх	С.Мяндасмаа О.Очгэрэл	Яамны аппаратын тайлан	Холбогдох баримтыг бүрдүүлж, шүүхэд өгөх, шүүхийн шийдвэрийг үндэслэн тушаал гарган, шийдвэрлэх	2022.12.01	Б.Бат-Эрдэнэ
8	СХОХ	Барьцааны өглөгийн дансны үлдэгдлийг цэгцлэн, олон жилийн насжилттай, тодорхойгүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэх	Н.Баярсайхан О.Очгэрэл	Хөрөнгө оруулалтын тайлан	Барилгын ажлын барьцааны өглөгийн хугацааг тодруулах, эзэнгүй, олон жилийн насжилттай өглөгийг төсөвт төвлөрүүлэх	2022.12.01	Ч.Ренчиндамба
9	СХОХ	Үндсэн хөрөнгийн эзэмшигчийн картыг цэгцлэх, бүртгэлийг сайжруулах	Г.Алтангэрэл О.Очгэрэл	Яамны аппаратын тайлан	Эзэмшигчийн шилжилт, хөдөлгөөнийг ня-бо бүртгэлийн программанд шинэчлэн оруулах	2022.12.01	Ч.Ренчиндамба
10	СХОХ	Санхүүгийн сахилга батыг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хязгаарлалттай дүгнэлт үүсгэсэн, цаашид үүсгэж болзошгүй асуудлын талаар бодиттой ажил зохион байгуулж, биелэлтийг ирүүлэх	Г.Алтангэрэл	Төсөвт болон ТӨҮГ-ын удирдлага	Ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, биелэлтийг ирүүлэх	2022.08.25	Ч.Ренчиндамба





Байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт

№	Байгууллагын нэр	Дүгнэлт	Тайлбар
1	ЗТХЯ-ны аппарат, хөрөнгө оруулалт	Зөрчилгүй	
2	"Иргэний нисэхийн ерөнхий газар"	Хязгаарлалттай	
3	"Монголын төмөр зам" ТӨХК	Хязгаарлалттай	
4	"МИАТ" ТӨХК	Зөрчилгүй	
5	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ	Хязгаарлалттай	
6	"Далайн захиргаа" УТҮГ	Зөрчилгүй	
7	"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	Зөрчилгүй	
8	Замын сан /Төлбөр авах цэг/	Зөрчилгүй	
9	"Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ	Хязгаарлалттай	
10	"Архангай АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
11	"Булган АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
12	"Говь-алтай АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
13	"Дархан АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
14	"Дорноговь АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
15	"Завхан АЗЗА" ТӨХК	Сөрөг	
16	"Орхон АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
17	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
18	"Хархорин АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
19	"Талын зам" ТӨХК	Зөрчилгүй	

20	"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
21	"Төв АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
22	"Баянчандмань АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
23	"Эрдэнэсант АЗЗА" ТӨХК	Хязгаарлалттай	
24	"Увс АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
25	"Ховд АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
26	"Харгуй" ТӨХК	Зөрчилгүй	
27	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
28	"Налайх АЗЗА" ТӨХК	Хязгаарлалттай	
29	"Багануур АЗЗА" ТӨХК	Зөрчилгүй	
30	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал	Зөрчилгүй	
31	Автоимпекс ХХК	Түүвэрт хамруулсан	
	<b>ИНЕГ-ын харъяа байгууллагууд</b>		
	Аймгуудын нисэх буудлууд /10 аймаг/	зөрчилгүй	
	Хэнтий, Сүхбаатар аймгийн нисэх буудлууд	хамрагдаагүй	
	Сэргээн засах амралт ТӨААТҮГ	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
	Аюулгүй байдал, хамгаалалтын алба	хамрагдаагүй	
	Ховд аймгийн нисэх буудал	Хязгаарлалттай	
	Буянт ухаа ОУНБ	зөрчилгүй	

МОНГОЛ УЛСЫН  
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
**ЭХ ХУВЬ**  
 Саид Ториин нарийн бичгийн  
 даргын захирамж /1/30